

ТАНИЛЦУУЛГА

Иргэдээс Сүхбаатар аймгийн төрийн захиргааны байгууллага,
албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл
гомдлын шийдвэрлэлтийн тухай

/2023 оны 3-р улирлын байдлаар/

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 08 тоот албан даалгаврын дагуу аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас 2023 оны 3-р улирлын байдлаар ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайланг нэгтгэн танилцуулж байна.

Тайлант хугацаанд аймгийн нийт төрийн захиргааны байгууллагад 10694 өргөдөл гомдол, санал хүсэлт, талархал ирсний 10353 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлт 96,8 хувийн үзүүлэлттэй байна. Хугацаа болоогүй 268 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд судлагдаж байна.

Аймгийн хэмжээний нийт төрийн захиргааны байгууллагад иргэдээс хандаж гаргасан өргөдлийг агуулгаар нь ангилахад Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст хандаж гарсан өргөдөл, хүсэлт зонхилж байна. Мөн тус онд өвөлжилт хаваржилт хүндэрсэнтэй холбоотой өвс, тэжээлийн дэмжлэг, хадлангийн газар хүссэн хүсэлт 963 ирсэн нь нийт өргөдлийн 11,8 хувийг эзэлж байна.

3-р улирлын байдлаар гэр хүссэн 269 иргэний өргөдөл ирснийг гэр төсөл хэрэгжүүлэн 100 иргэнийг гэртэй болголоо.

2023 оны 3-р улирлын байдлаар аймгийн Засаг даргад хандаж 100 өргөдөл, гомдол ирснээс Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжин ирсэн 40 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг өгсөн.

Аймгийн нийт төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдлыг нэгдүгээр, өргөдлийг ирүүлсэн хэлбэрээр нь ангилан хоёрдугаар, нийт өргөдлийн агуулга болон зонхилж байгаа асуудлыг гуравдугаар хавсралтаар тус тус харуулав.

Аймгийн Засаг даргын Тамгын газар

Аймгийн засаг даргыноны.....дүгээр
сарын.....ний өдрийн.....тоот албан
бичгийн нэгдүгээр хавсралт

Иргэдээс Сүхбаатар аймгийн төрийн захиргааны байгууллага, албан
тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлын
шийдвэрлэлтийн байдал

/2023 оны 3-р улирлын байдлаар/

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	Шийдвэрлэлтийн хувь
1	Аймгийн ЗДТГ	100	91	-	-	9	91,0
2	Агентлаг	6644	6501	-	-	143	97,8
3	Сумд	3950	3761	74	-	116	95,2
	ДҮН	10694	10353	74	-	268	96,8

Аймгийн засаг даргыноны.....дүгээр
сарын.....ний өдрийн.....тоот албан
бичгийн хоёрдугаар хавсралт

Иргэдээс Сүхбаатар аймгийн төрийн захиргааны байгууллага,
албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл
гомдол, санал хүсэлт /хэлбэрээр/

/2023 оны 3-р улирлын байдлаар/

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Үүнээс:				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Аймгийн ЗДТГ	100	60	40	-	-	-
2	Агентлаг	6644	6434	206	-	4	-
3	Сумд	3950	2376	290	384	900	-
	Дүн	10694	8870	536	384	904	-

Аймгийн засаг даргыноны.....дүгээр
сарын.....ний өдрийн.....тоот албан
бичгийн гуравдугаар хавсралт

Иргэдээс Сүхбаатар аймгийн төрийн захиргааны байгууллага, албан
тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдол,
санал хүсэлтийн агуулга /Хувиар/

/2023 оны 3-р улирлын байдлаар/

1	Сүхбаатар аймаг	Нийт 10694 өргөдөл, гомдол, хүсэлт, талархал ирснээс: 1. Өргөдөл, хүсэлт –10491 2.Санал - 123 3. Гомдол - 65 4. Талархал - 15		
		1. Хөдөлмөр халамж үйлчилгээний асуудлаар	4662	
		2. Өвс тэжээл, хадлангийн газар хүссэн хүсэлт	963	
		3. Газрын асуудлаар	620	
		4. Ажлын байртай холбоотой	479	
		5. Тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудлаар	471	
		6. Нийгмийн даатгалтай холбоотой асуудлаар	329	
		7. Гэр орон байр хүссэн	269	
		8. Буцалтгүй тусламж, мөнгөн дэмжлэг хүссэн	224	
		9. Стандарт хэмжил зүйтэй холбоотой	241	
		10. Иргэний бүртгэлтэй холбоотой	219	
		11. Боловсролын асуудлаар	197	
		12. Шагнуулах хүсэлт	181	
		13. Татвартай холбоотой	170	
		14. Байгаль орчинтой холбоотой	136	
		12. Цаг үеийн асуудлаар	350	
		14. Бусад асуудлаар	1183	
НИЙТ - 10694				